

ЧАНАР, ТӨЛБӨРИЙН ХЯНАЛТЫН ЖУРМЫН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2024 оны 11 дүгээр сарын 11

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.5-д “даатгуулагчид үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар болон зардлын төлбөрт хяналт тавьж, энэ хуулийн 14.8.7-д заасан журамд тусгагдсан шалгуур хангасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд төлбөр олгох;” 23 дугаар зүйлийн 23.2.3-т “эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын болон төлбөрийн хяналтыг энэ хуулийн 14.8.7-д заасан журмын дагуу цахим болон бусад хэлбэрээр хэрэгжүүлэх;”, 14 дүгээр зүйлийн 14.8.7-д “даатгалын гэрээний дагуу худалдан авсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын болон төлбөрийн хяналтыг хэрэгжүүлэх журмыг олон улсын эмнэл зүйн удирдамж ашиглан батлах” гэж заасны дагуу хуулийн заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор “Чанар, төлбөрийн хяналт”-ын журмын төслийг шинэчлэн боловсруулж, танилцуулж байна.

УИХ-аас 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдөр Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэлийг хийх хууль эрх зүйн орчныг бий болгож Эрүүл мэндийн тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулж, эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэлийг эхлүүлэн дөрөв дэх жилдээ хэрэгжүүлж байна. Шинэчлэлээр төрөөс зардлыг нь хариуцах тусламж, үйлчилгээнд улсын төсвөөс олгох санхүүжилтийг ЭМДС руу нэгтгэж, нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжиж, стратегийн худалдан авагчийн тогтолцоог бий болгох нөхцөл бүрдсэн. Стратегийн худалдан авагчийн гол мөн чанаруудын нэг нь чанартай тусламж, үйлчилгээг худалдан авах явдал бөгөөд энэ хүрээнд 2021, 2022 онуудад чанар, төлбөрийн хяналтын журмыг батлуулж мөрдүүлсэн бөгөөд энэ удаад 3 дахь өөрчлөлтийн хувилбарыг боловсруулан хүргүүлж байна.

Энэхүү журмын төслийг боловсруулах хүрээнд дараах үе шаттай арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

1. ЭМДЕГ-т чанар, төлбөрийн хяналттай холбоотой ирүүлсэн албан бичиг, шүүхийн маргааны тохиолдлууд, бодлогын даалгавар зэрэг бичиг баримтын судалгаа хийж хэрэгжилтийн явцад ЭМДЕГ болон ЭМБ-дад тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлж, ижил төстэй хөгжиж буй улс орнуудын сайн туршлагаас судалж журмын төслийг шинэчлэн боловсрууллаа.
2. Лавлагаа шатлалын ЭМБ-аас үзүүлэх тусламж, үйлчилгээний 25 хувь нь тухайлсан нарийвчилсан хяналтын шалгууртай байдаг. Тиймээс нэхэмжлэлийн чанарын хяналтын шалгуурыг шинэчлэх, шинээр боловсруулах ажлыг Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр зохион байгуулж 20 мэргэжлийн салбар зөвлөл, нийгэмлэг, холбоодтой гэрээ байгуулан гүйцэтгүүлж, нэхэмжлэлийн чанарын хяналтын шалгуурын төслийг эмнэлзүйн практикт ажилласан туршлагатай, тэргүүлэх эмч, мэргэжилтнүүдийн оролцоог хангасан хэлэлцүүлгүүдийг зохион байгуулж, сайжруулах саналуудыг тусгалаа.
3. Нэхэмжлэлийн төлбөрийн хяналтын шалгуурыг оношийн хамааралтай бүлэг тус бүрд өвчний түүхийн мэдээлэлд үндэслэн боловсрууллаа.
4. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас тохиолдлоор санхүүжүүлдэг тусламж, үйлчилгээнүүд тухайлбал; сэргээн засах тусламж, үйлчилгээ, өдрийн эмчилгээ, гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээ, оношилгоо, шинжилгээний багцын шалгуурын төслийг боловсруулж сум тосгоны эмч, мэргэжилтнүүдийн болон өрхийн ангахаа ухааны эмч мэргэжилтнүүдийн нэгдсэн холбоонд албан бичгээр хүргүүлэх, ЭМДЕГ-ын албан ёсны сайт дээр байршуулж санал авах ажлуудыг зохион байгуулсан.

Энэхүү танилцуулга нь 1) ЭМД-ын чанар, төлбөрийн хяналтын үр дүн, 2) ЭМДҮЗ-ийн 2022 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан чанар, төлбөрийн хяналтын журмыг өөрчлөх шаардлага, шинэчилсэн журамд гарсан гол өөрчлөлтүүд, журмын өөрчлөлттэй холбоотой гарах үр дүн гэсэн агуулгаас бүрдэнэ.

Нэг. ЭМД-ын чанар, төлбөрийн хяналтын үр дүн

Стратегийн худалдан авалтын үндсэн үүрэг нь ЭМДСанг бүрдүүлэх, бүрдүүлсэн сангаас авах тусламж, үйлчилгээг тогтоох, тусламж, үйлчилгээг хэнээс, ямар аргаар, ямар үнээр худалдан авахыг шийдэхийн зэрэгцээ тусламж, үйлчилгээний чанарт хяналт тавьж, чанартай тусламж, үйлчилгээг худалдан авдаг. Шинэчлэлээс хойш эдгээр чиг үүргүүдийг хэрэгжүүлэх бүхий л дүрэм, журмууд батлагдан мөрдөгдөж байна. ЭМДЕГ-ын чанар, төлбөрийн хяналтын тогтолцооны шинэчлэлийг хийхдээ дараах үндсэн 2 зорилтыг дэвшүүлсэн байдаг. Үүнд:

1. ЭМД-ын чанар, төлбөрийн хяналтын тогтолцоог бий болгох;
2. Эмнэлзүйн удирдамжийн хэрэглээг дэмжсэн хөшүүргийг бий болгох;

ЭМДЕГ-ын нэхэмжлэл, нэхэмжлэлийн хяналт, эмнэлзүйн удирдамжийн хэрэглээнд дүн шинжилгээ хийж, шинэчлэл нь анхны дэвшүүлсэн зорилтод хүрсэн эсэхийг үнэлэхэд дараах үр дүн гарч байна.

1. Худалдан авагч байгууллагын чанар, төлбөрийн хяналтын тогтолцоог бий болгох;

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.8.7-д “даатгалын гэрээний дагуу худалдан авсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын болон төлбөрийн хяналтыг хэрэгжүүлэх журмыг олон улсын эмнэл зүйн удирдамж ашиглан батлах” гэж заасны дагуу лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагаас худалдан авч буй тусламж, үйлчилгээний тохиолдлыг хянах нэхэмжлэлийн нарийвчилсан хяналтын шалгуурыг эмнэлзүйн удирдамж ашиглан боловсруулж, ЭМДҮЗ-ийн тогтоолоор батлуулан, мөрдөж байна. Мөн, нэхэмжлэл хянах журмыг ЭМДЕГ-ын даргын тушаалаар батлуулж, мөрдөж байна. Ингэснээр ЭМДЕГ чанар, төлбөрийн хяналт хийх журам, аргачлалтай болж, өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж байгаа бөгөөд ЭМДЕГ-ын чанар, төлбөрийн хяналт үр дүнг дараах хэсэгт тоймлон хүргэж байна.

Нэхэмжлэлийн цахим хяналт: ЭМДЕГ-т тусламж, үйлчилгээний сая гаруй нэхэмжлэл сар бүр ирүүлдэг бөгөөд тэдгээрийг 100 хувь, маш богино хугацаанд, цахимаар хянаж, төлбөрийн тохируулга хийх ба илт алдаатай нэхэмжлэлийн төлбөрийн хасалт хийгддэг. Нэхэмжлэлийн цахим хяналтаар төлбөр хасагдсан тохиолдлын эзлэх хувь 2021, 2022, 2023 онуудад **13%, 4%, 1.2%** болж алдаа эрс буурсан нь ЭМБ-ууд батлагдсан журмыг баримтлан нэхэмжлэлээ зөв илгээж хэвшиж буйг харуулж байна. Цахим хяналтаар хамгийн түгээмэл илэрдэг алдаа нь тусламж үйлчилгээг давхардуулан нэхэмжилдэг буюу яаралтай тусламжийн нэхэмжлэлийг хэвтүүлэн эмчлэх тусламжтай давхардуулан нэхэмжилдэг, сэргээн засах тусламж, үйлчилгээг уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээтэй зэрэг нэхэмжилдэг, ОХБ, онош, үйлдлийн кодууд хоорондоо зөрдөг зэрэг шалтгаанууд тэргүүлдэг.

Нэхэмжлэлийн нарийвчилсан хяналт:

Түүвэр: Нэхэмжлэлийг цахимаар хянасны дараа нарийвчилсан хяналт хийх түүврийг санамсаргүй болон зорилтот аргаар тодорхойлдог. Учир нь нэхэмжлэлд өвчтөний түүхийн мэдээлэл байдаггүй, өвчтөний түүх бүрэн цахимжаагүй, бүх нэхэмжлэлийг нарийвчлан хянах нөөц хязгаарлагдмал байдаг ч түүврийн хэмжээг жил бүр нэмэгдүүлж байгаа (График 1) ба энэ нь хяналтын хүрээг тэлэх хүрээнд хийгдсэн хэд хэдэн ажлын үр дүн юм. Үүнд;


- Нарийвчилсан хяналт хийх тохиолдлын тоог мэргэжилтнүүдэд жигд хуваарилж, ачааллыг тэнцүүлсэн;
- Мэргэжлийн шинжээч эмч нартай гэрээ байгуулж хяналт хийх мэргэжилтний тоог нэмэгдүүлсэн зэрэг арга хэмжээг дурдаж болно.

Эх олонлог: Түүвэрлэгдсэн тохиолдлууд нь нарийвчилсан хяналтаар шалгуур хангаагүй бол алдааны хэмжээгээр тухайн түүврийг авсан онош, үйлдэлд хамаарах тусламж, үйлчилгээнд төлбөрийн




хасагдлыг ногдуулах аргыг 2022 оны 11 дүгээр сараас ашиглаж байна. Эх олонлогт ногдуулсан төлбөрийн хасагдлын эзлэх хувь нийт нэхэмжлэлийн 3 хүртэлх хувийг эзэлдэг (График 2).

График 2. Нэхэмжлэлийн хяналтын үр дүн



Энэ аргыг нэвтрүүлснээс хойш ЭМБ-ууд нарийвчилсан хяналтын шалгуур хангахын тулд илүү хүчин чармайлтууд гаргаж, шалгуур хангагдаагүйн улмаас үүсэх амжилтгүй нэхэмжлэлийн хувь тогтвортой буурсан. 2022 оны 9 дүгээр сард нийт ЭМБ-ын амжилтгүй нэхэмжлэлийн хувь 48 хувь байсан бол 2024 оны 9 сард 18 хувь болж бараг гурав дахин буурсан (График 3. Амжилтгүй нэхэмжлэлийн хувь).

График 3. Амжилтгүй нэхэмжлэлийн хувь



Нэхэмжлэлийн нэмэлт хяналт: ЭМД-ын нэхэмжлэлийн хяналтын үр дүнг дээшлүүлэх, тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор мэргэжлийн шинжээч эмч нарыг сонгон шалгаруулж, тоо хэмжээ хамгийн их нэмэгдсэн 21 ОХБ-ийн тусламж, үйлчилгээнд нэмэлт хяналт хийлгэхэд сонгогдсон тусламж, үйлчилгээний 57 хувь нь чанарын шаардлага хангахгүй байна гэсэн дүгнэлт гарсан (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Шинжээч эмч нарын нарийвчилсан хяналтын үр дүн


ОХБ код	ОХБ-ын нэр	Хянасан тоо хэмжээ	Шалгуур хангаагүй тусламж, үйлчилгээний тоо	Хасалтын хувь
370011	Уламжлалт анагаах ухааны хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ	745	736	99%
051881	Зүрхний даралт ихсэх өвчин	749	707	94%
310013	Яаралтай тусламж, үйлчилгээ - Ногоон /В	1,921	1,747	91%
014201	Тархины судасны цүлхэн	523	470	90%
310016	Гэмтлийн яаралтай тусламж, үйлчилгээ - Шар	434	382	88%
043021	Амьсгалын тогтолцооны бусад өвчнүүд	1,862	1,582	85%
300017	Эрсдэлтэй жирэмсний хяналтын багц	728	608	84%
041381	Вирус пневмони	1,022	753	74%
0211542	Болрын цийлт	1,103	688	62%
240012	Эрчимт эмчилгээ В	729	446	61%
310011	Яаралтай тусламж, үйлчилгээ - Улаан	783	467	60%
1017011	Чихрийн шижин	546	323	59%
370024	Уламжлалт анагаах ухааны хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ	295	173	59%
051511	Зүрхний дутмагшил	707	368	52%
0723611	Элэгний фиброз ба цирроз	691	333	48%
370021	Уламжлалт анагаах ухааны хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ	413	190	46%
310015	Гэмтлийн яаралтай тусламж, үйлчилгээ - Улаан	46	19	41%
240011	Эрчимт эмчилгээ А	459	177	39%
0142044	Тархины судасны цүлхэн	62	21	34%

300033	Өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээ	1,198	287	24%
310012	Яаралтай тусламж, үйлчилгээ - Шар /В	1,562	338	22%
041992	Хамрын таславчийн эмгэг	299	47	16%
300032	Өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээ	1,679	170	10%
0419941	Хамрын таславчийн эмгэг	716	6	1%
Нийт		19,294	11,043	57%

ЭМД-ын мессеж хяналт: 2022 онд ЭМДЕГ-тай гэрээтэй ЭМБ-аас тусламж, үйлчилгээ авсан иргэн, даатгуулагчийн утсанд мессеж илгээж, баталгаажуулах ажлыг туршилтаар эхлүүлсэн. Мессеж асуулга нь иргэн, даатгуулагч тухайн ЭМБ-аас тухайн тусламж, үйлчилгээг бодитоор авсан эсэхийг баталгаажуулах, эмнэлэг ЭМД-ын багцад орсон эм тариа, эмнэлгийн хэрэгсэл, оношилгоо, шинжилгээний зардлыг иргэний халааснаас төлүүлсэн эсэхийг тодруулах, тухайн эмнэлгийн үйлчилгээнд ерөнхий үнэлгээ өгөх зорилготой юм.

2022-2024 онд нийт 592,530 иргэнд судалгааны мессеж илгээхэд хариу ирүүлсэн иргэдийн 4% нь тухайн тусламж, үйлчилгээг огт аваагүй, 24% нь эмнэлгийн тусламж, үйлчилгээ авч байхдаа өөрийн зардлаар эм, тариа, эмнэлгийн хэрэгсэл авсан, 23%-ийг өөр ЭМБ-руу илгээж оношилгоо, шинжилгээнд хамруулсан, 12% нь эмнэлгийн тусламж, үйлчилгээнд сэтгэл ханамжгүй гэсэн хариултуудыг өгчээ. Мессеж судалгааг шалгаж, нотлогдсон тохиолдолд хариу арга хэмжээ авснаар иргэн, даатгуулагч тусламж, үйлчилгээ аваагүй байхад нэхэмжилсэн тохиолдол 81%-иар, эм тариа авхуулсан тохиолдол 87%-иар, өөр эмнэлэгт оношилгоо шинжилгээнд илгээсэн тохиолдол 79%-иар буурсан эерэг нөлөө үзүүлсэн. Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд иргэн, даатгуулагчийн өгсөн үнэлгээгээр дийлэнх иргэдийн сэтгэл ханамж тогтвортой өндөр буюу дунджаар 88 хувь, 12 хувь нь сэтгэл ханамжгүй байна (График 4).

График 4. Эмнэлгээс тусламж авсан иргэдийн ерөнхий сэтгэл ханамж



ЭМБ-ын газар дээр хийх хяналт, шалгалт:

- Нэхэмжлэлийн мэдээлэл, иргэдийн санал, гомдлыг шалгах, гэрээний үүргийн биелэлтийг үнэлэх, сонгон шалгаруулалтад ирүүлсэн нөөцийн мэдээлэл бодитой эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх зорилгоор ЭМБ-ын газар дээр нь очиж хяналт, шалгалт хийдэг. 2022 онд нэгдсэн сонгон шалгаруулалт явагдсантай холбоотой ЭМБ-аас ирүүлсэн нөөцийн мэдээллийн үнэн, бодит байдлыг үнэлэх зорилгоор улсын хэмжээнд

1 сарын хугацаанд, нийт 234 лавлагаа шатлалын ЭМБ-ын, давхардсан тоогоор 1611 ОХБ-ийн нөөцийг үнэлж 1046-г баталгаажуулж, 436 ОХБ-ийг шаардлага хангахгүй тул гаргасан хүсэлт шаардлага хангахгүй гэсэн дүгнэлт гаргасан.

- 2023 онд мессеж судалгааны үр дүнг судалж, иргэн даатгуулагчийн зөрчигдсөн эрхийг хамгаалах, хууль бус үйлдэл, зөрчлийг арилгуулах, хариуцлага тооцох, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх зорилгоор 71 ЭМБ-уудад хяналт, шалгалт хийсний үр дүнд ЭМД-ын санд учруулсан 11,671,933 төгрөгийг нөхөн төлүүлж, тусламж, үйлчилгээ авах үедээ нэмэлт төлбөр, эм тариа, эмнэлгийн хэрэгсэл авхуулсан 6 иргэний төлбөрийн баримтыг үндэслэн 455,000 төгрөгийг буцаан олгуулсан.
- 2023 онд ЭМБ-ын газар дээр нь очиж хийсэн хяналт, шалгалтаар 7 ЭМБ-ын гэрээг түдгэлзүүлэх, 3 ЭМБ-ын гэрээ цуцлах, 7 ЭМБ-аас иргэн, даатгуулагчийн гаргасан нэмэлт төлбөрийг буцаан олгуулах, 8 ЭМБ-д авлага тооцох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.


ЭМБ-уудад тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах хүрээнд хүргүүлсэн зөвлөмж:

Нэхэмжлэлийн нарийвчилсан хяналтын үр дүнд үндэслэн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулахад чиглэсэн зөвлөмжийг 2022 оны 09 дүгээр сараас 2024 оны 06 дугаар сар хүртэлх хугацаанд 480 (давхардсан тоогоор) эрүүл мэндийн байгуулгуудад хүргүүлсэн.

2. Эмнэлзүйн удирдамжийн хэрэглээг дэмжсэн хөшүүргийг бий болгох:

Дэлхийн өндөр хөгжилтэй улс орнууд анагаахын шинжлэх ухааны судалгааны үр дүнд үндэслэн оношилгоо, эмчилгээний арга буюу эмнэл зүйн удирдамжийг шинэчлэн боловсруулах ажилд ихээхэн хэмжээний хөрөнгө мөнгө, цаг хугацаа зарцуулж, олон тооны эрдэмтэн судлаачид энэ чиглэлээр тогтмол ажиллаж институцлагдсан байдаг. ЭМЯ, ЭМДЕГ-аас удаа дараагийн хэлэлцээрийг Wolters Kluwer компанитай хийсний үр дүнд Монгол улсын өнцөг булан бүрийн эмнэлгийн бүх эмч, мэргэжилтнүүд UpToDate - эмнэлзүйн цахим платформыг ашиглах эрхийг маш бага үнээр авах боломжийг бүрдүүлсэн. Мөн, ЭМД нэхэмжлэлийн нарийвчилсан хяналтын шалгуурыг нотолгоонд суурилсан эх сурвалж ашиглаж боловсруулах, хяналтын үр дүнг санхүүжилттэй уялдуулснаар эмнэлзүйн удирдамжийн хэрэглээг дээшлүүлэх аргыг нэвтрүүлсэн.

UpToDate- эмнэлзүйн цахим платформын хандалтын тоо 2021 оноос хойш тогтмол өсөж 2024 оны эцэс гэхэд нийт 628 мянган хандалт бүртгэгдэх магадлалтай байгаа бөгөөд нийт хэрэглэгчийн 53 хувь нь эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд, 37 хувь нь резидент эмч, анагаахын оюутнууд, үлдсэн хувийг бусад ангиллын мэргэжилтнүүд эзэлж байна (График 5).



Хамгийн их хайлт хийсэн хандалт нь хүүхэд, нярай судлал, дотрын өвчин, халдварт өвчин, эх барих эмэгтэйчүүд судлалын чиглэлээр хайлт хийсэн байх ба жил ирэх тусам хайлтын тоо нэмэгдэх хандлагатай байна. Хандалтын 41 хувь нь тухайн эмнэлзүйн чиглэлийн хүрээнд эмчилгээний шийдвэр гаргахад ашиглах зорилгоор хийгджээ.

№	Хамгийн их хандалттай нарийн мэргэжлийн чиглэл	2021 он	2022 он	2023 он	2024 оны эхний хагас жил
1	Хүүхэд нярай судлал	34,170	42,837	59,150	33,820
2	Дотрын өвчин судлал	26,664	23,012	35,664	16,695
3	Халдварт өвчин судлал	32,786	38,507	48,460	26,801
4	Эх барих, эмэгтэйчүүд судлал	23,128	29,988	41,128	19,955
5	Эм судлал	16,344	27,380	37,866	19,862

Хоёр. ЭМДҮЗ-ийн 2022 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан чанар, төлбөрийн хяналтын журмыг өөрчлөх шаардлага, шинэчилсэн журамд гарсан гол өөрчлөлтүүд

Тулгамдсан асуудал 1: ЭМБ-аас ирүүлж байгаа нэхэмжлэлийн тоо, мөнгөн дүн жил бүр маш хурдацтай өсөж байгаа бөгөөд нэхэмжлэлийн нарийвчилсан хяналтын шалгуураар хууран мэхлэх үйл ажиллагааг илрүүлэх боломж хязгаарлагдмал байна. ЭМДЕГ-т сард дунджаар 2022 онд 700,000, 2023 онд 943,000, 2024 онд 1,000,000 гаруй нэхэмжлэл ирж, мөнгөн дүн жил бүр 20 хувиар өсжээ. Энэ нь санхүүжилтийн шинэчлэлээс өмнө эм, тарианы зардлын 50 гаруй хувь нь албан бус халаасны төлбөрөөс бүрддэг байсан зэрэг асуудал эрс буурч хүн амын эрүүл мэндийн хангагдаагүй хэрэгцээг гүйцэлдүүлсэнтэй холбоотой байж болох ч төлбөрийн хяналтыг сайжруулах шаардлагатайг харуулж байна.

Журмын гол өөрчлөлт, гарах үр дүн: Чанар, төлбөрийн хяналтын хүрээг өргөжүүлж, төлбөрийн хяналтын аргуудыг хэрэгжүүлэхээр журамд тусгасан. ЭМД-ын нэхэмжлэлийн хяналтад төлбөрийн хяналтыг нэвтрүүлж, нэхэмжлэлийн хяналтад түлхүү ашигласнаар аливаа хууран мэхлэх, завших оролдлогоос сэргийлэх, тэдгээрийг илрүүлэх, хариу арга хэмжээ авах боломж бүрдэнэ. Төлбөрийн хяналтыг хийх тохиолдлыг тодорхой нөхцөл хангасан буюу хууран мэхлэх үйл ажиллагаа хийсэн байж болзошгүй ЭМБ, тусламж, үйлчилгээг сонгох аргачлалаар түүвэрлэх ба төлбөрийн хяналтыг хэрэгжүүлэхдээ тухайн тусламж, үйлчилгээний зардлын үндсэн бүрэлдэхүүн тус бүрийн төлбөрийн хэмжээг шалгах байдлаар цахим системд суурилан хэрэгжүүлж, төлбөрийн хяналтын оночийг нэмэгдүүлэх, хяналтын үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх ач холбогдолтой. Мөн, төлбөрийн хяналтын үр дүнгийн бүртгэл үүсгэж, хариу арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлснээр хууран мэхлэх үйл ажиллагааг дорвитой бууруулна.

Тулгамдсан асуудал 2: Чанарын шалгуур ашиглаж нарийвчилсан хяналт хийснээр өвчтөний түүх хөтлөлт, түүхийн бүрдэл, нотолгоонд тулгуурласан шийдвэр гаргалт мэдэгдэхүйц сайжирсан ч өвчтөнд гарах эмнэлзүйн үр дүнд дорвитой ахиц гарахгүй байна. 2023 онд хамгийн их нэхэмжлэл ирүүлсэн хэвтүүлэн эмчлэх эмийн эмчилгээний ОХБ-ийг авч үзэхэд амьсгалын тогтолцооны өвчин 1 дүгээрт орсон ба тэдгээр тохиолдлын ¼-ийг 30 хоногийн дотор эмнэлэгт давтан хэвтүүлэн эмчилжээ. Иргэн даатгуулагчид давтан тусламж үзүүлсэн тохиолдлыг эрүүл мэндийн байгууллагаар судалж үзэхэд дүүргийн нэгдсэн эмнэлгүүд, амаржих газрууд тэргүүлж байна (Зураг 1). Өөрөөр хэлбэл иргэнийг бүрэн эмчлээгүй, эмнэлгээс эрт гаргасан, гарах үед шаардлагатай зөвлөмжийг өгөөгүйгээс эмнэлэгт давтан хэвтэх шалтгаан болж байгаа нь тусламж, үйлчилгээний чанарыг системтэй үнэлж, чанар, төлбөрийн хяналтын аргуудын хоорондын уялдааг хангуулах шаардлагатайг нотолж байна.

ТАЙЛАНТ ОН	ТАЙЛАНТ САР	АЙМАГ НЭР	ЭМБ ТӨРӨЛ	ЭМБ СТАТУС	ЭМБ НЭР	ТҮ ТӨРӨЛ НЭР	ТҮ НЭР
2024	(All)	(All)	(All)	(All)	(All)	(All)	Эмийн эмчилгээ

ДАВТАН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ АВСАН ДААТГУУЛАГЧДЫН МЭДЭЭЛЭЛ

(энэ үзүүлэлт нь тус ЭМБ-д тухайн сард, ижил оношоор ICD10-д давтан тусламж үйлчилгээ авсан даатгуулагчийн тоог харуулна)

НИС ЭМБ НЭР	HOSPITAL АЙМАГ НЭР	
Grand Total		2,696
Сонгинохайрхан НЭ	УЛААНБААТАР	235
Баянзүрх эмнэлэг	УЛААНБААТАР	202
Баянгол ЭМТ	УЛААНБААТАР	178
Эх хүүхдийн зрүүл мэндийн үндэсний төв	УЛААНБААТАР	162
Сүхбаатар НЭ	УЛААНБААТАР	154
Нийслэлийн хүрээ амаржих газар	УЛААНБААТАР	147
Сэтгэцийн зрүүл мэндийн үндэсний төв	УЛААНБААТАР	107
Чингэлтэй ЭМТ	УЛААНБААТАР	105
Хан-уул НЭ	УЛААНБААТАР	81
Улсын нэгдүгээр төв эмнэлэг	УЛААНБААТАР	78
Дархан-Уул аймгийн нэгдсэн эмнэлэг	ДАРХАН-УУЛ	76

ДАВТАН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ АВСАН ДААТГУУЛАГЧДЫН МЭДЭЭЛЭЛ

(энэ үзүүлэлт нь тус ЭМБ-д тухайн сард, тухай тусламж үйлчилгээгээр давтан тусламж үйлчилгээ авсан даатгуулагчийн тоог харуулна)


НИС ЭМБ НЭР	HOSPITAL АЙМАГ НЭР	
Grand Total		8,364
Нийслэлийн хүрээ амаржих газар	УЛААНБААТАР	707
Эх хүүхдийн зрүүл мэндийн үндэсний төв	УЛААНБААТАР	653
Нийслэлийн өргөө амаржих газар	УЛААНБААТАР	648
Нийслэлийн амгалан амаржих газар	УЛААНБААТАР	545
Сонгинохайрхан НЭ	УЛААНБААТАР	436
Баянзүрх эмнэлэг	УЛААНБААТАР	393
Сүхбаатар НЭ	УЛААНБААТАР	259
Баянгол ЭМТ	УЛААНБААТАР	233
Ховд аймгийн БОЭТ	ХОВД	223
Орхон аймгийн БОЭТ	ОРХОН	216
Дархан-Уул аймгийн нэгдсэн эмнэлэг	ДАРХАН-УУЛ	214
Баян-Өлгий аймгийн нэгдсэн эмнэлэг	БАЯН-ӨЛГИЙ	211

Журмын гол өөрчлөлт, гарах үр дүн: Нэхэмжлэлийн чанарын хяналтыг нэхэмжлэлийн төлбөрийн хяналтын үйл ажиллагаатай давхардуулахгүйгээр хэрэгжүүлэхээр журамд заасан ба хяналтыг мэргэжлийн холбоод, нийгэмлэгийн боловсруулсан урьдчилан тогтоосон шалгуурын дагуу хийхээр тусгасан. Гэхдээ нэгж тусламжид ногдох шалгуурын тоо нэлээд их байгаа тул цаашид цөөрүүлэх саналыг тавьж байна. Нэхэмжлэлийн чанарын хяналтын оночийг дээшлүүлэх зорилгоор чанарын хяналтад хамрагдах ЭМБ болон тусламж, үйлчилгээг тодорхой нөхцөлөөр шүүж тодорхойлно. Нэхэмжлэлийн чанарын хяналтын үр дүнгийн бүртгэл үүсгэж, хариу арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлснээр тусламж, үйлчилгээг үндэслэлтэй, чанартай үзүүлэхэд ихээхэн нөлөө үзүүлнэ гэж үзэж байна.

Мөн, тусламж, үйлчилгээний чанарын бүрэлдэхүүн хэсгүүдийг системтэй судалж, чанарыг сайжруулахад ашигладаг эмнэлзүйн аудитыг илүү өргөн утгаар журамд тусгаснаар олон улсад ашигладаг чанар сайжруулах аргыг хэрэгжүүлэх боломж бүрдэнэ.

ЭМБ-ын газар дээр нь хийх хяналт, шалгалтыг илүү өргөн хүрээгээр цогцоор нь шалгах нөхцөл, ашиглах арга, хэрэгжүүлэх дараалал, үе шаттай авах хариу арга хэмжээг тусгаснаар ЭМБ-ын газар дээр нь хийх хяналт, шалгалтыг чанаржуулж, улмаар иргэн даатгуулагчид үзүүлэх тусламжийн чанарыг ахиулах, хууран мэхлэх үйл ажиллагааг бууруулах нөлөө үзүүлнэ.

Тулгамдсан асуудал 3: Эрүүл мэндийн байгууллагууд хүсэлт гаргаж нэмэлт хяналт хийлгэх тохиолдлын тоо өссөнтэй холбоотой мэргэжилтнүүдийн өдөр тутмын ажлын ачаалал, хөндлөнгийн шинжээч хөлсөөр ажиллуулах зардал нэмэгдсэн. 2022 оны 10 дугаар сараас 2024 оны 06 дугаар сар хүртэлх хугацаанд 75 ЭМБ-аас 172 (давхардсан тоогоор) хүсэлтийг хүлээн авч, 10 тусламж, үйлчилгээний 21,696 түүвэрт нэмэлт хяналтыг хэрэгжүүлсэн.



Журмын гол өөрчлөлт, гарах үр дүн: Журамд гомдлыг шийдвэрлэх үе шат, хариуцах эзэн, зарцуулах хугацаа, үйл явцыг тусгайлан нэг бүлэгт оруулсан. Чанар, төлбөрийн хяналтыг хэрэгжүүлэх арга, давтамж, нөхцөл, үе шатуудыг талуудад илүү ойлгомжтой болгож, хэрэгжилтийн явцад гарах ойлголтын зөрүү, алдаа, маргааныг багасгаж, ил тод байдлыг нэмэгдүүлнэ.

Тулгамдсан асуудал 4: Бүх шатны ЭМБ-дад олгох санхүүжилтийн хэмжээ мэдэгдэхүйц нэмэгдэхийн хирээр иргэн, даатгуулагч төвтэй тусламж, үйлчилгээг зохион байгуулах түүнчлэн сэтгэл ханамж, туршлагыг судалж, түүнээсээ суралцаж, сайжруулах арга хэмжээ хийгдэхгүй байна.

Журмын гол өөрчлөлт, гарах үр дүн: Тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулахад ашигладаг үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж, туршлагыг судлах аргыг ашигласнаар ЭМД-тай гэрээтэй ЭМБ-аас тусламж авсан иргэдийн ерөнхий сэтгэл ханамжийн түвшин, түүнд нөлөөлж буй хүчин зүйлүүдийг судалж, үр дүнг ЭМБ-ууд ашигласнаар иргэн төвтэй тусламж, үйлчилгээг зохион байгуулах боломж бүрдэнэ. Мөн, иргэдийн сэтгэл ханамжийн түвшинг олон нийтэд ил тод байршуулж иргэд, даатгуулагчид чанартай тусламж үзүүлдэг эмнэлгийг сонгож үйлчлүүлэхэд тусална.

Тулгамдсан асуудал 5: Чанар, төлбөрийн хяналтын журам хэрэгжсэнээс хойш зохион байгуулагдсан хурал, уулзалт, хэлэлцүүлгийн үеэр ЭМБ-ууд гаргасан санал, хүсэлтүүдийн дийлэнх нь чанар, төлбөрийн хяналт нь хэтэрхий өвчний түүхийн бичилтийг шалгах руу чиглэсэн, нарийвчилсан хяналтын шалгуурууд нь тусламж, үйлчилгээний үр дүн, чанарыг хэмждэггүй, хэрэв хяналтаар хасагдал ихтэй бол нэг төрлийн тусламж, үйлчилгээ үзүүлж буй эрүүл мэндийн байгууллагуудын төлбөрийн хасагдлын хэмжээ хэт өндөр болж, тухайн эмнэлгийн санхүүгийн байдлыг хүндрүүлдэг, нэгэнт зардлаа гаргаад тусламж, үйлчилгээгээ үзүүлсэн эрүүл мэндийн байгууллагын санхүүжилтийг эх олонлогийн аргаар нийтэд нь хасдаг, чанар, төлбөрийн хяналтыг хэрэгжүүлэх журмууд хоорондоо зөрчилддөг зэрэг асуудлуудыг хөндсөн байдаг.

Журмын гол өөрчлөлт, гарах үр дүн: Чанар, төлбөрийн хяналтаар илэрч буй алдаа дутагдлыг засахад дэмжлэг үзүүлэх арга хэмжээнүүдийг цогцоор нь нэвтрүүлснээр зөв нэхэмжлэл илгээдэг болно. Тухайлбал; ЭМБ-уудаас илгээсэн бүх нэхэмжлэлийн алдааг ЭМД цахимаар шалгаж, илэрсэн энгийн алдааг засварлах хугацааг олгосноор угаас илгээх ёсгүй байсан нэхэмжлэлийг “цахим хяналтаар хасагдсан тохиолдол” гэж тооцон их хэмжээний мөнгөн дүн хасагдсан мэт хий тоо баримтыг арилгаж, ЭМБ-ууд алдаагүй нэхэмжлэл илгээдэг болно. Мөн нэхэмжлэлтэй холбоотой гарч буй асуудлуудын бүртгэлийг сайжруулж, түүний үр дүнд үндэслэн цахим мэдээллийн систем ашиглаж ЭМБ-дад мэдээлэл хүргүүлэх, эргэх холбоотой ажиллах, удаа дараа алдаагаа давтсан тохиолдолд хариуцлага тооцоход ахиц гарна. Төлбөрийн хасагдлыг түүвэр авсан эх олонлогт ногдуулан хасалт хийхдээ бүхлээр нь бус шалгуур хангасан онооны хувиар тооцож ногдуулах өөрчлөлтүүдийг оруулсан.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР